



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/14

Мэргэн хошуу

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1, 5.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаагаа сунгуулах хүсэлт иргэдийн газар эзэмших эрхийн хугацааг нэгдүгээр хавсралтад заасны дагуу сунгасугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулсан газар эзэмшигчидтэй гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Г.Ганболд)-д, гэрээнд заасан зориулалт, нөхцөл шаардлагын дагуу газраа эзэмшихийг газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТБОЛД

23751933



Газар болон эзэмшлийн мэдээлэл

Эзэмшлийн				Өмнөх Захирамжийн			
Ургийн овог /иргэн/	Эцэг эхийн нэр /иргэн/	Иргэн /хуулийн этгээд/-ийн нэр	Регистр	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн дугаар
0	1	2	3	4	5	6	7
1		Цахирцагдан гол ХХК	5068053	2019.05.30	27		0

Үргэлжлэл

Өмнөх газрын				Газрын			
д/д	Нэгж талбарын дугаар	Хугацаа /жил/	Хэмжээ /мкв/	Байршил	Эзэмшлийн зориулалт	Сунгах хугацаа /жил/	
0	9	10	11	12	13	14	
1	2318001370	5	2317779	2-р Баг Хараат, Шар булгын ам	Ашиглах	5	